

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 116 / А / 565

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Дүрмийг мөрдүүлж, батлагдсан орон тоо бүтцээр ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал)-т, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.
4. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2012 оны 06/25 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД



Д. САРИНХҮРЭЛ



Монгол Улсын Шадар сайд,  
Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
...12 сарын 12-дрийн 116/А/565  
тоот тушаалын хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Эрүүл мэндийн бүх байгууллагуудад "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба"/баг (цаашид ЭМТҮЧАБ-ын алба гэх) ажиллана.

1.2. ЭМТҮЧАБ-ын алба нь тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, эрсдэл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, зохицуулах үүрэг бүхий нэгж байна.

1.3. ЭМТҮЧАБ-ын алба нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

1.4. Чанарын удирдлагын тогтолцооны чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллагууд, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, зөвлөл, иргэний төлөөлөл нь ЭМТҮЧАБ-ын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг байна.

### Хоёр. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны бүтэц, зохион байгуулалт, гишүүдийн чиг үүрэг

2.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, түргэн тусламжийн төв, нийгмийн эрүүл мэндийн төв, сэргээн засах төв, сувилахуйн төв, сувилалд тусламж, үйлчилгээний дар хүрээ, бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, үйлчлэх хүрээний хүн амын тоо зэргээс хамаарч 3-8 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны ЭМТҮЧАБ-ын алба ажиллана. ЭМТҮЧАБ-ын албыг албаны дарга удирдах бөгөөд тухайн эрүүл мэндийн байгууллагын захирал/даргын шууд удирдлагад хамаарагдаж, удирдлагын багийн гишүүн байна.

2.2. ЭМТҮЧАБ-ын албанд:

- Албаны дарга
- Чанарын менежер
- Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер
- Тусламж, үйлчилгээний чанарын мэдээллийн асуудал хариуцсан эмнэлгийн мэргэжилтэн ажиллана.

2.3. ЭМТҮЧАБ-ын алба нь орон тооны бус гишүүдтэй байна. Гишүүдэд эмчилгээ эрхэлсэн, нийгмийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн, сэтхүү, аж ахуйн асуудал эрхэлсэн захирал, поликлиникийн эрхлэгч, сувилахуйн албаны дарга,



лабораторийн эрхлэгч, даатгалын, эмгэг судлаач эмч, их эмч, эмнэл зүйн эм судлаач, тархвар/халдвар судлаач, статистикч их эмч, мэдээллийн технологич, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер орно.

2.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны орон тооны бус гишүүд нь тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад дараахь чиг үүргийг хэрэгжүүлэн оролцоно.

- 2.4.1. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, поликлиникийн эрхлэгч - Тухайн байгууллагын эмнэл зүйн үйл ажиллагаатай холбоотой талуудын уялдаа холбоо ханган, хамтран ажиллах үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.4.2. Санхүүгийн албаны дарга - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, урамшуулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэн, зарцуулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.4.3. Сувилахуйн албаны дарга - Сувилахуйн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.4.4. Тархвар/халдвар судлаач - Халдварын сэргийлэлт, хяналтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар, үйлчлүүлэгч болон эмч мэргэжилтний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулна.
- 2.4.5. Их эмч, эмнэл зүйн эм судлаач - Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, гаж нөлөөг судлах, тендерээр нийлүүлэгдэж буй эмийн чанар, жор бичилт, эмийн эмчилгээний чанар, аюулгүй байдалд мэргэжлийн дагуу хяналт тавьж ажиллана.
- 2.4.6. Мэдээллийн мэргэжилтэн статистикч их эмч - Тусламж, үйлчилгээний чанарын албаны үйл ажиллагаанд шаардлагатай, тоо мэдээлэл цуглуулан, дүн шинжилгээ хийхэд мэдээлээр хангаж ажиллана.
- 2.4.7. Эмгэг судлаач эмч - Эмч, мэргэжилтнийг эмнэлзүйн эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэх, тохиолдол бүрийг бүртгэх, шалтгааныг тодруулах, шалтгаан хамаарлын шинжилгээ хийх багт орж ажиллах, эргэн мэдээлэх, суралцах үйл ажиллагааг чиглүүлэн ажиллана.
- 2.4.8. Эрүүл мэндийн даатгалын эмч - Даатгалын байгууллагатай хамтран ажиллах, даатгуулагчийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, учирч буй эрсдэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.4.9. Мэдээллийн технологич - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлаар холбоотой мэдээллийн технологийн арга хэрэгсэлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, үйлчлүүлэгчийн нууцлалыг хадгалах, чанар, аюулгүй байдлын мэдээний санг байгууллагын түвшинд үүсгэн, хэвийн үйл ажиллагааг хангах,



- хэрэглэгчийн нууцлалыг хадгалах, холбогдох эрхийн хязгаарлалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээнэ.
- 2.4.10. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх, шалгалт тохируулгад хамруулах, хэмжих хэрэгсэлийн баталгаажилтыг стандартын байгууллагатай хамтран гүйцэтгэх, тоног төхөөрөмжид хугацаат засвар үйлчилгээ үзүүлэх, тоног төхөөрөмжтэй холбоотой доголдол гарсан бол анхааруулах журмыг ЭМТҮЧАБ-ын алба /баг/-тай хамтран гаргаж, хэрэгжилтийг хангах үүргийг гүйцэтгэнэ.
- 2.5. Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, клиник, ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд нь тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний цар хүрээ, бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, үйлчлэх хүрээний хүн амын тоо зэргээс хамаарч, 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ЭМТҮЧАБ-ын багтай байна.
- 2.6. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь тогтмол хуралдаж, хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргана. Шийдвэр нь зөвлөмж, дүгнэлтийн хэлбэртэй байна.
- 2.7. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь тухайн байгууллагын албан ёсчигийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.
- 2.8. Эрүүл мэндийн байгууллага нь чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах болон ЭМТҮЧАБ-ын алба/багийн үйл ажиллагааны зардлыг байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 2.9. ЭМТҮЧАБ-ын албаны даргаар дараахь нийтлэг шаардлага хангасан мэргэжилтнийг томилно.
- 2.9.1. Эрүүл мэндийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан;
  - 2.9.2. Эрдмийн эсвэл мэргэжлийн зэрэг цолтой;
  - 2.9.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай;
  - 2.9.4. Багаар ажиллах чадвартай;
  - 2.9.5. Ёс зүйн алдаа, зөрчил гаргаж байгаагүй.
- 2.10. Чанарын менежер болон аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежерээр дараахь нийтлэг шаардлага хангасан мэргэжилтнийг томилно.
- 2.10.1. Эрүүл мэндийн байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан;
  - 2.10.2. Эрдмийн буюу мэргэжлийн зэрэг цолтой;
  - 2.10.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр 1-ээс дээш жил ажилласан туршлагатай;
  - 2.10.4. Багаар ажиллах чадвартай;
  - 2.10.5. Ёс зүйн алдаа зөрчил гаргаж байгаагүй.
- 2.11. Тусламж, үйлчилгээний чанарын мэдээллийн асуулал хариуцсан эмнэлгийн мэргэжилтэн нь дараахь нийтлэг шаардлага хангасан байна.
- 2.11.1. Эрүүл мэндийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан;



- 2.11.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр 1-ээс дээш жил ажилласан туршлагатай;
- 2.11.3. Багаар ажиллах чадвартай;
- 2.11.4. Ёс зүйн алдаа зөрчил гаргаж байгаагүй.

2.12. ЭМТҮЧАБ-ын алба/багийн ажилтнуудын цалин хөлс нь Төрийн албаны тухай хуулийн 57.2.4 болон бусад хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалын цалин, докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ.

### **Гурав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны чиг үүрэг**

- 3.1. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- 3.2. Чанар сайжруулах чиглэлээр ажилтнуудад сургалт, хяналцан туршлага солилцох ажлыг тогтмол зохион байгуулж, тасралтгүй суралцаж үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.3. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврыг мөрдүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана.
- 3.5. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзүүлнэ.
- 3.6. Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй халдварын сэргийлэлт, хяналтын, эмчилгээний, ёс зүйн, эмийн, болон бусад хороо, зөвлөл, албадуудтай хамтран ажиллан, үйл ажиллагаанд хяналт тавьж, чанар сайжруулах үйл ажиллагаанд татан оролцуулна.
- 3.7. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаар мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, судалгаа хийх, туршлага судлах, зөвлөх үйлчилгээг зохион байгуулна.
- 3.8. Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгаа явуулж, үр дүнг тооцно.
- 3.9. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлнэ.
- 3.10. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгч ба эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлаар чанарын судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийнэ.



3.11. Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн мэргэжилтний аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах орчин бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын талаар санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

3.12. Байгууллагын хэмжээнд чанар сайжруулах талаар хэлэгжүүлж буй бүх арга хэмжээг бүртгэн, мэдээллийн сан байгуулж олсон шалт амжилтыг байгууллагынхаа бүх тасаг/нэгжүүдэд дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж урамшуулан ажиллана.

3.13. Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл тавих, хамтын мэдээлэл солилцох, суралцах, эргэх холбооны хэрэгсэл болгох зорилго бүхий чанар, аюулгүй байдлын буланг тогтмол ажиллуулна.

3.14. Байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх ажлыг хамтран ажиллах, тэдний хүсэлтийг шийдвэр гаргалтанд тусгасан талаар эргэ мэдээлнэ.

3.15. Шинэ ажилтанг чиглүүлэх сургалтын хөтөлбөрт чанар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар тусгах, эмч, эмнэлгийн ажилтнуудад чанар, аюулгүй байдлын сургалтыг тогтмол зохион байгуулна.

3.16. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шалгуу үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, өөрийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлнэ.

3.17. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр тухайн байгууллагад мөрдөх дүрэм, журам заавар, хяналтын хуудсыг хуульд нийцүүлэн боловсруулан, мөрдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана.

3.18. Эрүүл мэндийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын ажлыг нэг шалгуур болгон оруулж дүгнэнэ.

3.19. ЭМТҮЧАБ-ын алба нь тасаг/нэгжүүдэд чанар, аюулгүй байдлын баг байгуулж ажиллана.

oOo